



БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ТАТВАРЫН ХЭЛТЭС

2022 оны 01 дүгээр сарын 21

Татварын хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-
шинжилгээ, үнэлгээний тайлан

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын зорилтын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, удирдамжаар хангах, санал хүсэлтийг хүлээн авч, аймаг орон нутгийн талаар мэдээлэл өгөхөд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагийн 2021 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдийг хамруулсан.

Үүнд:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:

- Яамны сайдтай Аймгийн засаг даргын байгуулсан гэрээний тухайн агентлагт хамааралтай заалтын хэрэгжилт
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт
- Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт
- Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох:

- Байгууллагын ил тод байдлын үнэлгээ
- Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.3-т заасан арга зүйгээр дээрх 9 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн ирүүлсэн тайлангаас гадна холбогдох нэгж, байгууллагаас нэмэлт тодруулга авах, хамааралтай нотлох баримт болон статистик мэдээлэлтэй харьцуулалт хийсэн болно.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 2 үзүүлэлтийг байгууллагын тайлантай танилцаж үнэлгээ өгсөн. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 5 үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 2 үзүүлэлтийг тайлан, холбогдох хэлтэс үнэлгээ өгөх болон статистик мэдээлэлд үндэслэн үнэлгээг өгсөн.

Яамдын сайд нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг **ХШҮХ**-ээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж баталгаажуулсан үнэлгээг хэрэглэсэн болно.

Нэг: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг үнэлэхдээ тухайн байгууллагад хамааралтай болон бүх төрийн байгууллага хэрэгжүүлж ажиллахаар тусгасан заалтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Тухайн агентлагт хамааралтай заалтын тоо	Хувь	Бүх агентлагт хамааралтай заалтын тоо	Хувь	Дундаж хувь
		2	85	4	90	87.5

1.2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

1	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Зорилтын тоо	Зорилтын хэрэгжилт	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Дундаж хувь
		1	100	3	100	100

Хоёр: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

2.1. Яамдын сайд нартай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний үүргийн биелэлт

№	Үнэлгээ хийсэн холбогдох хэлтэс	Заалтын тоо	Хувь
1	ХШҮХэлтэс	4	100

2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

№	Үнэлгээ хийсэн холбогдох хэлтэс	Баталгаажуулсан үнэлгээ
1	ХШҮХ	96.6

2.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4-р хавсралтын шалгуур үзүүлэлтийн дагуу ТЗУХ-ээс газар дээр нь үзэж танилцаж үнэлгээг өгсөн.

№	Төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Дундаж хувь
1	95	95	95

2.4. Эдийн засаг нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлт

Д/д	Шалгуур үзүүлэлт	2020 оны үзүүлэлт	2021 оны үзүүлэлт	Биелэлт /хувь/
1	Сумын татварын орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/	131.5	134.1	100
2	Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/	119.1	110.1	100
3	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/	86.1	111.5	100
4	Татварын өрийн барагдуулалтын хувь	100	100	100
5	Цалингийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/	100	106.1	100
Дундаж үнэлгээ				100

2.5. Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлтийг газар дээр нь үзэж үнэлгээ өгсөн.

Д/д	Үндсэн үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийг дүгнэх үндэслэл	Үнэлэх аргачлал	Авбал зохих оноо	Авсан оноо
Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс					
ХШҮ-ний зөвлөмж (2020 он)	2020 үйл ажиллагааны үр дүнгээр зөвлөмжийн хэрэгжилт (25 оноо)	ХШҮДАХ-т зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлсэн байдал	Хугацаандаа ирүүлсэн байдал	5	3
		Зөвлөмжийн хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан эсэх	Төлөвлөгөө гаргасан	5	5
		Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Хэрэгжилтийн хувиар тооцох	15	14.2

Төлөвлөлт, тайлагналтын чанар	Төлөвлөлт, тайлагналтын чанар байдал (15 оноо)	Тухайн жилийн төлөвлөлт	Өгсөн сургалт, зөвлөмжийн дагуу төлөвлөлтөө засч сайжруулсан байдал	10	10
		Бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт	Тайлагналтын чанар сайн	5	5
Хэсгийн дүн				40	37.2
Хоёр.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс					
Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилт, СӨГ-ын шийдвэрлэлт, цахим үйлчилгээ	Төрийн албаны зөвлөлийн зөвлөмж, хууль дүрэм журмын биелэлтийн байдал, СӨГ, хариутай бичгийн шийдвэрлэлт, цахим үйлчилгээ(40 оноо)	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол (Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам) -ын дагуу хэрэгжүүлсэн байдал	Тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан ажлын байрны тодорхойлолтыг баталсан байдал	5	5
			Албан тушаалын тодорхойлолтод эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга дарж албажуулсан байдал	5	5
		Төрийн албаны зөвлөлийн 05 дугаар тогтоол (Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам)-аар хувийн хэргийг бүрдүүлсэн байдал (20 оноо)	Хувийн хэргийг журамд заасны дагуу бүрдүүлсэн байдал	10	10
			Хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийсэн байдал	5	5
			Төрийн албан хаагчийн анкетыг бүрэн бөглөж, албажуулсан байдал	5	5
		Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн (20 оноо)	Ёс зүйн зөвлөл байгуулсан эсэх	5	5
			Ёс зүйн зөвлөлийн жилийн төлөвлөгөө гаргаж баталсан эсэх, жилийн эцсийн хэрэгжилт гаргаж, ёс зүйн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байдал	5	5
			Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг байгууллагын дотоод журамд тусгасан эсэх	5	5
			Ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулсан тоо, хамрагдсан хүний тоо	5	5

		Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөхөхтэй холбогдолтой дүрэм заавруудын хэрэгжилт (25 оноо)	Сул орон тоо гарсан үед түр орлон гүйцэтгэх журмын дагуу нөхсөн эсэх	10	8	
			Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмыг хэрэглэсэн эсэх, хэрэглэсэн бол зөв хэрэглэсэн эсэх	5	5	
			Томилгооны зөрчилтэй томилогдсон албан хаагчдын тоо, зөрчил арилгасан байдал	5	3	
			Сул орон тоо гарснаас хойш 21 хоногийн дотор захиалгыг ТАСЗ-д хугацаандаа хүргүүлсэн байдал	5	5	
		Хариутай бичиг, санал өргөдөл, гомдолын шийдвэрлэлт (10 оноо)	СӨГ-ын шийдвэрлэлтийн хувиар	5	5	
			Хариутай бичгийн шийдвэрлэлт	5	5	
		Цахим үйлчилгээний нэвтрүүлэлт (15 оноо)	Байгууллагын фейж хуудас, хөгжүүлэлтийн байдал	10	10	
			ERP системийн нэвтрүүлэлт ашиглалтын байдал	5	3	
		Хэсгийн дүн			100	94
		Гурав. Хууль, эрх зүйн хэлтэс				
Хууль зүйн сургалт, сурталчилгаа болон архив, албан хэрэг хөтлөлт, авлигаас	Эрх зүйн актын боловсруулалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах, Хууль зүйн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа	Байгууллагын эрх зүйн шийдвэрийн боловсруулалт Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 91 дүгээр тогтоолын хэрэгжилт. Хариуцсан ажил үйлчилгээний чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн хууль зүйн сургалт, сурталчилгаа,	Тушаал, шийдвэр боловсруулах, эрх зүйн үндэслэлд хяналт тавих (ЗЕХ-ийн 29 дүгээр зүйл) хэрэгжилт, үр дүн	5	5	
	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс		Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангасан эсэх, мэдээний чанар, хугацаа	10	5	

	урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	мэдээллийн үйл ажиллагаа (20 оноо)	Хэрэглэгч, иргэдэд зориулан зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, бэлтгэсэн эрх зүйн гарын авлага, түгээсэн арга хэлбэр, хамралт, оролцоо	5	5
		Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилт Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-уудын үйл ажиллагаа (20 оноо)	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт.	10	9.4
			Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачилсан аян, арга хэмжээ зохион байгуулсан эсэх	5	4
			Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулан томилж, томилсон этгээдийн ХАСХОМ-ийг 30 хоногт авсан бол	5	5
		Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилт Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах үйл ажиллагаа (20 оноо)	Захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны баримт бичгийг зохион бүрдүүлэхэд тавигдах шаардлагыг хангасан эсэх	5	5
			Байнга, түр, устгах данс бүртгэл жагсаалтыг Төрийн архиваар жил бүр батлуулж хэвшсэн эсэх г.м	5	5
			2021 оны хуваарийн дагуу Төрийн архивт баримтаа шилжүүлсэн буюу цаасан баримтыг цахимд шилжүүлсэн эсэх	5	5

			Баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахад зохион байгуулсан арга хэмжээ	5	5
Хэсгийн дүн				60	53.4
Дөрөв. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс					
2021 оны 02 тоот захирамж, ногоон байгууламж нэмэгдүүлэх	Жилийн дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний оролцоо	2021 оны аймгийн засаг даргын 02 тоот захирамжийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх (20 оноо)	Хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө гаргасан эсэх,	5	5
			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиас тооцох	15	15
		Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын санал санаачилга	Хаврын мод тарих арга хэмжээний оролцоо, модны ургалтын хувь	10	10
			Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн, намрын мод тарилтад оролцсон байдал	10	10
Хэсгийн дүн				40	40
Тав. Нийгмийн бодлогын хэлтэс					
Монгол бичгийн хэрэглээ, жендэрийн хуулийн хэрэгжилт	Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшин, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хөдөлмөрийн авулгүй байдал эрүүл ахуй	Монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлсэн байдал	Байгууллагын нийт албан хаагчдын хамрагдалтын хувиар	10	10
			Батламж авсан албан хаагчдын эзлэх хувийг оноонд шилжүүлж тооцох	5	0
			Монгол бичгээр хэвлэгддэг сонин хэвлэл захиалсан байдал, байгууллага, албан хаагчдын хаягжилтыг монгол бичгээр шийдсэн эсэх	5	5
		Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах /11.4/ Жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтын талаар ойлголт, мэдээлэл авах, сургалтад хамрагдах; /11.5/	Ажил олгогчийн эрх үүрэг, ажилтны эрх үүрэг, гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгасан байдал	3	3
			Дотооддоо сургалт зохион байгуулсан байдал	2	2

	Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулан, шалгалт авсан байна. /17,4/ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд саадгүй орчин бүрдүүлсэн байх	Сургалтыг 2 ба түүнээс дээш удаа зохион байгуулсан байдал	2	1,5
		Гадна налуу зам, дотор налуу зам, 00-д бариулаар тоноглогдсон байдал	3	0
Хэсгийн дүн			30	21,5
Нэгтгэсэн дүн			270	246.1
Хувь			100	91.1

Ололттой болон дутагдалтай асуудал:

Байгууллагад өгсөн 6 заалт бүхий зөвлөмжийг 100 хувь, нийтлэг зөвлөмжийг 95 хувиар хэрэгжүүлэн ажилласан байна.

Үндэсний бичгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 9 заалт бүхий төлөвлөгөө гарган, 98 хувьтай хэрэгжүүлсэн. Монгол бичгийн сургалтад албан хаагчдаа бүрэн хамруулж, гарааны судалгаа, сорил авч, 64,7 хувь нь А, В үнэлэгдсэн. Албан хаагчдынхаа монгол бичиг сурсан ахицаар нь үнэлж, урамшуулал олгосон.

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан МУ-ын ҮАБЗ-ийг мэдээ, мэдээллээр хангах журмын 3 дугаар хавсралтын 10-д 2 танилцуулах мэдээг улирлаар ирүүлэхээр заасан боловч өнгөрсөн онд ирүүлээгүй байна.

Зөрчилтэй томилгооны зөрчил арилгах, ERP цахим мэдээллийн системийг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж хэвших /Ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдолыг ERP-д бүртгэж шилжүүлэх/

Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

3.1.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын хүрээнд журмын 9 дүгээр хавсралтын дагуу газар дээр нь үзэж үнэлгээ өгсөн.

№	Шалгуур үзүүлэлт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал		
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100

5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	100
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	100
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	-
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	-
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	-
Хэсгийн дундаж хувь:		100
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;		
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	100
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	50
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	0
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	100
Хэсгийн дундаж хувь:		70
Хэрэгжилтийн дундаж хувь: 85		

Ололттой болон дутагдалтай асуудал: Үзүүлж байгаа үйлчилгээний арга хэлбэрийг боловсонгуй болгох ажлын хүрээнд 7 суманд пос машин байршуулснаар иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн.

3.2.Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ

№	Төсөв санхүү, өмч хөрөнгийн үзүүлэлтийн нийт оноо			
1	Аудитын дүгнэлт	Зөрчилгүй дүгнэлттэй бол 5 оноо, түүвэрт хамрагдсан бол 4 оноо, зөрчилтэй дүгнэлттэй бол 0 оноо	5	5

2	Шилэн дансны хэрэгжилтийн байдал	Хугацаандаа мэдээлсэн мэдээ бүрт 1 оноо, хугацаа хоцроосон мэдээ бүрт 0,5 оноо, мэдээлээгүй мэдээ бүрт 0 оноо өгч 10 хүртэл оноогоор дүгнэнэ.	10	9.9
Нийт оноо			15	14.9
Хувь			100	99.3

**Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн
жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүн**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	87.5	0,2	
	2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100		
Дундаж		93.7	18.7	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Яамдын сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилт	100	0,5	
	2.Аймгийн Засаг даргаас агентлагийн дарга нартай байгуулсан гэрээ /Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт/	96.6		
	3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт	95		
	4.Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	100		
	5.Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт	91.1		
Дундаж		96.5	48.2	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан	85	0,3	
	2.Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлт	99.3		
Дундаж		92.1	27.6	
Ерөнхий үнэлгээ			94.5	

Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх үзүүлэлт тус бүрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд дараах асуудлыг цаашид анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллагын болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж хэрэгжилт үр дүнг тооцож байх.

Ногоон байгууламжийн хувьд 2021 онд тарьсан модны ургац дээр арчилгааг үргэжлүүлэн арчилгааг хийх. Мөн байгууллагын гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах.

Байгууллагын гадна налуу зам тавьж, ариун цэврийн өрөөг бариулаар тоноглон, ХБИ үйлчлүүлэхэд саадгүй орчинг бүрдүүлэх.

Монгол бичгийн сургалтыг дуусгаж, албан хаагчдад Батламж авахуулах.

Байгууллагын ил тод байдлын мэдээллийг тухай бүр байршуулан хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг цахимд хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулах.

Татварын хэлтэс дээр байгаа 4, 6 суманд зөрчилтэй томилгоо байгаа тул зөрчлийг арилгаж журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах журмыг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэхэд анхаар

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс